



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А/ЗН

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 21 дүгээр зүйлийн 21.1.2, 22 дугаар зүйлийн 22.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийгэмд тулгамдаж буй хөгжлийн асуудлуудыг шийдвэрлэхэд залуучуудын дуу хоолой, үзэл бодол, бүтээлч санаачилга, шийдлийг дэмжиж, чадавхжуулахад чиглэгдсэн “Шинэ Сэргэлт-NEXTGEN” төслийн уралдааны анхан шатны шалгаруулалтыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Цэцэгмаа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Гишүүдэд:

Д.Отгонбаяр (Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч)

Б.Оюунтуяа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Т.Раднаабүд (Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

С.Отгонжаргал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

Н.Батсүмбэр (Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

Ц.Батцоож (Аймгийн Залуучуудын хөгжлийн зөвлөлийн тэргүүн)

Нарийн бичгийн дарга:


Ч.Дашбаяр (Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга)

2.

2. Төслийн уралдааны анхан шатны шалгаруулалтыг журмын дагуу зохион байгуулж, гүйцэтгэл үр дүнг танилцуулж ажиллахыг ажлын хэсэгт (Д.Цэцэгмаа)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН